



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/10

Хархорин сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2007 оны 186 дугаар захирамжийн 35, 2005 оны 29 дүгээр захирамжийн 73, 2006 оны 13 дугаар захирамжийн 11, 2005 оны 48 дугаар захирамжийн 36 дугаарт байгаа 4 өрхийн нэр бүхий 8 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2.Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ



401100019

MyDoc.Zahiramj./ZDTG/